

**ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙГ АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААР ТӨСВИЙН  
БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 5 дугаар  
сарын 19-ний өдөр

Улаанбаатар  
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын  
гишүүн Л.Эрдэнэчимэг

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2015 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы 2015 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлээд, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг 2015 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаараа хийлээ.

Төслийн анхны хэлэлцүүлгийг тус Байнгын хорооны хуралдаанаар хийх үед Улсын Их Хурлын гишүүн Ч.Улаан, Ц.Даваасүрэн нар хуулийн төслийн 2 дугаар зүйлийн ""эрчим хүч, төмөр зам" гэж нэмэх" гэснийг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн "уул уурхайн" гэснийг тус тус хасах санал гаргасан боловч хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно. Энэ асуудлаар Улсын Их Хурлын гишүүн Ч.Улаан, Ц.Даваасүрэн нар цөөнх боллоо.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Р.Амаржаргал хуулийн төсөлд эрчим хүч, төмөр зам, уул уурхайн салбарт Засгийн газар хувь нийлүүлж, ашгаас нь эргэн төлөгдөх нөхцөлтэй байгуулсан гэрээний дагуу авсан Засгийн газрын зээл, баталгаа өрийн хязгаарт хамаарахгүй гэсэн байна, дээрх салбаруудын хувийн сектор, төр хувийн хэвшил хамтарсан нөхцөлд авсан зээлийг өрийн хязгаарт оруулах эсэхийг хуулиар яаж зохицуулахыг шийдэх хэрэгтэй гэсэн саналыг гаргасан болно.

Хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Та бүхэнд тараасан.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**

**Б.БОЛОР**

